

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэвээний Цэцэнхүү	Дугаар	L208
Оршин суугаа аймаг	Увс аймаг	Оршин суугаа сум	Малчин сум
Төрсөн газар	Малчин сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Тус хийдийн тэргүүн лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цалгарын хийд	Сүм хийдийн дугаар	УВМЛ 011
Одоогийн сүм хийд	Ганданрашдаржаалин	Сүм хийдийн дугаар	УВМЛ 012
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 10	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх

### Увс аймгийн Малчин сумын Цалгарын хийд, Ганданрашдаржаалин хийд

Билэг-Өрнөх: Увс аймгийн Малчин сумын Ганданрашдаржаалин хийдийн тэргүүн Цэвээний Цэцэнхүү ламтай уулзаж байна аа.

Цэцэнхүү: За баярлалаа. Тэгээд энэ Цалгарын хүрээ нь болохлээр арван баядын хошууны шашны гол төв нь байсан юм аа. Анх энэ Төгс буянтын хүрээнээс салбарлаж тэр хүрээний хурлын дэгийг авч хэрэглэсэн гэж өвгөчүүл ярьдаг юм аа, тэгээд энэ Баяд, Дөрвөдүүд нь болохоор Алтайн цаад говиос нүүж ирэхдээ тэнд нэг сүм бариад тэрнийхээ тэр баяр ёслолыг хийж байхад нь Алтайд байна гэснийг , галтай дай гэж сонсоод анх дүрвэж ирж нутагласан. Тэгээд энэ Баядууд нь болохоор энэ одоогийн энэ Малчин сумын Хяргасын энүүгээр ингэж нутаглаад 1780-аад оны үед энэ Цалгарт ирж суурьшаад анхан сүм хийд төвлөрсөн юм байна аа. Тэр нь хуучин одоо энэ өвгөн Цалгар гэж суурь нь байгаа юм аа. Тэрнээсээ 1890-ээд онд дахин нүүж энэ залуу Цалгар гэж энд суурьшиж байгуулагдсан юм аа. Тэгээд тэр үед Төвдөөс Гачин лам ирж энэ цам тогтоох бас ажлаар явж байгаад энэ сүм байгаа газар нь жоохон догшин ширүүн газар юм гээд. Тэгээд энэ Дэжээлингийн хүрээ тасарч энэ урагшаа очиж цам тогтож тэгсэн тийм юу байдаг юм аа. Тэгээд тэр залуу Цалгар нь тэр тухайн үед байгуулагдаж тэгж явж байх үедээ 1500 гаруй лам нартай байсан байна аа. Тэгээд хувьсгалын өмнө нэг 130-аад ламтай, тэгээд арван баядын хошууны хүрээ Цалгарын хүрээ гэж нэртэй болсон хойно 1937, 1938 оны үед л хэлмэгдэлт явж хийд хаагдсан. Хамгийн сүүлд 4 лам үлдэж хурал номоо хурж байгаад тэгээд 3 нь үлдэж тэр өдөр нь 3 лам хурал хурах ёсгүй учраас хурал маань одоо ингээд тасарлаа , диваажинд уулзая гэж хэлээд салсан.Тэр 3 хүний хүү тэр Бандийсанж, Ёндон гэдэг хүн ерэн онд ирж буцаж энэ хийдийг сэргээж үйл ажиллагаа явуулсан юм аа. Тэр үед нь энэ залгаа Хяргас сумаас Тэс, Наранбулаг, Зүүн говийн энэ хуучин хийдэд шавилж байсан 20 гаруй хөгшин лам ирж энд хурал ном хураад нээж анх үйл ажиллагаа эхлүүлсэн юм байна. Тэрнээс хойш нэг 6 ламтай,

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байнгын үйл ажиллагаа явуулдаг. Барилга байгууламж хийдийн хувьд бас арай гайгүй тохижсон ингээд үйл ажиллагаагаа үргэлжлүүлээд явуулж байгаа ийм хийд байгаа юм аа.

Билэг-Өрнөх: За таньд баярлалаа.